

МОНГОЛД ШУВУУ АЖИГЛАХ АЯЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ

Пүрэв-Очирын Ганхуяг¹, Пүрэвдоржийн Амартүвшин², Хумбаагийн Түмэндэлгэр³

Зэрлэг амьтан судлах хамгаалах төв¹, Ikh Montis LLC², Гайхамшигт говь Аялал жуулчлалын холбоо³, Монголын шувуу ажиглагчдын клуб^{1,2,3}

Харилцах хаяг: gankhuyag@wscc.org.mn

хураангуй. Монгол оронд аялал жуулчлалын салбар үүсэн бий болоод 60 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Сүүлийн жилүүдэд тусгай сонирхолын аяллыг хөгжүүлэхээр идэвхитэй ажиллаж байгаа. Хэдий тийм боловч тусгай сонирхолын аялал жуулчлалын хөгжил өнөөг хүртэл сул байгаа нь нэгдсэн бодлого байгаагүйтэй холбоотой байсан. Үүний нэг тод жишээ нь шувуу ажиглах аялал юм. Олон улсад өндөр хөгжсөн энэ аялал Монголд 20 гаруй жилийн өмнөөс эхлэсэн ч өнөөг хүртэл тогтвортой бус байгаа нь энэ аялалд шаардагдах үндсэн нөхцөлүүд хангагдаагүйтэй холбоотой байна. Шувуу ажиглах аяллыг аялал жуулчлалын компаниуд өөрсдийн нөөц боломжийг ашиглан бие даан гүйцэтгэж ирсэн хэдий ч үр дүнтэй аяллын маршрут болон мэргэжлийн хөтчийн нөөц, мэдлэг чадвар дутагдаж, тогтвортой хөгжих боломжийг хязгаарлаж байна. Тиймээс Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас тусгай сонирхолын аяллуудыг хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын болон бусад холбогдох газруудтай хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Түлхүүр үг: тусгай сонирхолын аялал, шувуу ажиглах аяллын хөгжил

Тоодог 1:42-47, 2014

Оршил

Шувуу ажиглах аялал гэгдэх тусгай сонирхолын энэ аяллын түүх нь шувуу ажиглах хоббитой шууд холбоотой. Шувуу ажиглах хобби 100 гаруй жилийн түүхтэй бөгөөд Америкт хийгдсэн судалгаагаар тус улсын 5 хүн тутмын нэг нь шувуу ажиглах хоббитой гэжээ (Pullis La Rouche 2006). Өнөөдөр дэлхийн хэмжээнд шувуу ажиглах хоббид ажил мэргэжил үл харгалзан бүхий л насны хүмүүс дурлаж хошуурах болсон. Олон оронд шувуу ажиглах клубууд байх бөгөөд зарим нь сая гарсан гишүүдтэй байх нь бий. Дэлхийн хэмжээнд шувуу ажиглах сонирхолтой хүмүүсийн тоо 20 дугаар зууны сүүлд огцом өсөж, улс, тив дамжин шувуу харахаар аялах болсон байна (Christ et al. 2003). Шувуу ажиглах хобби өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад манай орны иргэдийн дунд энэ чиглэлийн хобби хөгжөөгүй.

Шувуу ажиглагчид шувуудад хайртай, мөн тэдгээрийн амьдрах орчныг хайрлах, хамгаалах сэтгэлгээг өндөр эзэмшсэн байдаг. Энэ утгаараа шувуу ажиглах хобби хүмүүсийн экологийн талаарх мэдлэгийг маш хурдацтай нэмэгдүүлдэг. Дээр дурьдсан зүйлс нь энэхүү хобби байгаль хамгааллын талаасаа ямар их ач холбогдолтой болохыг харуулж байна.

Түүнчлэн гадны орнуудад шувуу ажиглагчид өөрсдийн цуглуулсан мэдээгээ өөр хоорондоо мэдээллийн бүхий л сувгуудаар байнга солилцдог бөгөөд энэ нь тухайн улс орны шувуу судлалын шинжлэх ухаанд маш үнэ цэнэтэй мэдээ баримт болдог тул энэ утгаараа шинжлэх ухааны ач холбогдолтой юм (Krieger 2005).

Тиймээс ард иргэдийнхээ дунд энэ төрлийн хоббиг хөгжүүлэх мөн шувуу ажиглах аяллыг дэмжин бодлого болгон хэрэгжүүлэх нь байгалийн аялал жуулчлалыг зөв хөгжүүлэхэд дэмжлэг болохоос гадна иргэдийн байгаль орчноо хамгаалах, экологийн боловсролоо дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд бид энэхүү өгүүлэлдээ Монголд шувуу ажиглах аяллын өнөөгийн төлөв, хөгжүүлэх нөөц, боломжийн талаар тусгалаа.

Манай улсад 1990 оноос хойш байгалийн аялал жуулчлал сонирхдог гадны жуулчдын тоо өссөн. Байгалийн аялал жуулчлалыг дагаад 2000 он гарснаас хойш гадны жуулчдын аяллын баг дотор шувуу ажиглагчид олширсон бөгөөд энэ нь аялал жуулчлалын операторууд өөрсдийн шувуу ажиглах маршрут болон хөтөлбөртэй болох нөхцлийг бүрдүүлсэн. Үүнийг дагаад манай орны жуулчин хүлээж

авдаг байгууллагуудын мэргэжлийн хөтөч нарт шувуудын талаарх мэдлэгтэй болох шаардлагууд тавигдах болсон (Ганхуяг ба Амархүү 2012).

Шувуу ажиглах аялал гэдэг нь байгалийн баялаг болох жигүүртэн амьтдын амьдралын онцлог, үйл хөдлөл зэргийг мэргэжлийн болон хувийн сонирхолдоо тулгуурлан ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр аяллын үзмэр болгон ашиглаж, судлахыг хэлдэг (Dunne 2003, Alderfer and Dunn 2007).

Шувуу ажиглах аялал нь ердийн шувуу сонирхогч, мэргэжлийн шувуу ажиглагч гэсэн 2 хэлбэрийн хэрэглэгчтэй. Тодруулбал ердийн шувуу сонирхогч нь заавал тухайн зүйл шувуудыг хөөж таньж мэдэхийг илүүд үздэггүй ч өөрийн харсан шувуудын зүйлийн жагсаалтыг аялсан газар бүртээ бүртгэн, тэмдэглэж байдаг, байгаль дэлхийд, ялангуяа зэрлэг амьтан, шувуудад илүү ойр байж сэтгэлийн амралт, таашаал авахыг илүүд үздэг. Харин мэргэжлийн шувуу ажиглагчид нь шувууны аяллын тусгайлсан нарийн боловсруулсан төлөвлөгөөтэй байдаг бөгөөд шинэ зүйл шувуудыг харж өөрийн ажигласан шувуудын жагсаалтыг нэмэх, тухайн бүс нутгийн эндемик эсвэл олон улсын болон бүс нутгийн хэмжээнд ховордож буй шувуудыг байнга олж ажиглахыг эрэлхийлж байдаг. Түүнчлэн эдгээр аялагчид шувуудын нууцлаг амьдралыг таньж мэдэхийн төлөө өөрийн ихэнх чөлөөт цагийг зарцуулдаг (Alderfer and Dunn 2007).

Соёл, спорт, аялал жуулчлалын яам тусгай сонирхолын аяллуудыг 6 чиглэлээр хөгжүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүний нэг нь шувуу ажиглах аялал юм. Манай оронд шувуу ажиглах аяллыг хөгжүүлэхэд хамгийн эхэнд тулгамдаж буй зүйл бол олон янзын, аяллын үр дүнтэй, оновчтой маршрут болон түүнд бэлтгэгдсэн мэргэжлийн хөтөч нарыг бэлтгэх, сургах асуудал юм.

Шувуу ажиглах аяллын өнөөгийн төлөв

Монгол орны хувьд төрөөс баримтладаг шувууны аялал жуулчлалын нэгдсэн бодлого үгүй ба энэ чиглэлийн аяллыг тур опературууд өөрсдийн нөөц боломжийг ашиглан бие

даан гүйцэтгэж ирсэн байна. Үүнээс болж Монголын аялал жуулчлалын салбарт шувуу ажиглах аяллын талаарх мэдээлэл болон эдгээр аялалууд нь тус салбарын нийт орлогын хэдэн хувийг бүрдүүлж байгаа мөн ямар улсын хэрэглэгчид түлхүү ирдэг зэрэг судалгаа байдаггүй. Гэтэл гадны өндөр хөгжилтэй олон оронд төдийгүй хөгжиж буй зарим орнуудын аялал жуулчлалын салбарт шувуу ажиглах аялал нь хурдацтай хөгжсөн байх тул ногоон эдийн засагтай эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд маш үнэтэй хувь нэмэр болж байгаа.

Жишээ нь Америкийн United States Fish and Wildlife Service байгууллагын үнэлгээгээр АНУ-ын хэмжээнд шувуу сонирхогчдын аяллаас олсон дундаж орлого 32 тэрбум долларт хүрсэн бол Шотландад Royal Society for the Protection of Birds (RSPB) байгууллагын тооцоогоор зөвхөн Халзан бүргэдийг харах зорилгоор ирсэн шувуу сонирхогчдоос жилдээ 5-8 тэрбум фунт стерлингийн ашиг олсон гэжээ (Pullis, 2006).

Монголын аялал жуулчлалын байгууллагуудаас Juulchin, Nomadic Expeditions, Nomadic Journeys, Great Chinggis Tour, Selena Travel, Tsolmon Travel, Mongolica зэрэг байгууллагууд нь шувуу ажиглах аялал дээр бусдаасаа харьцангуй илүү туршлага хуримтлуулжээ. Дэлхийн хэмжээнд шувууны аяллыг зохион байгуулж, бүтээгдэхүүн болгон худалдаалж ашиг олдог Sunbird, Wings, Bird Quest, Zegrahm болон Spatia Wildlife зэрэг компаниуд ч манай орны аяллын зах зээлд оролцдог. Монголын аялал жуулчлалын байгууллагууд нь эдгээр олон улсын хэмжээнд шувууны аяллын бүтээгдэхүүн худалдаалдаг томоохон компаниудтай хамтран ажиллахаас гадна бие дааж өөрсдөө аяллуудыг хүлээн авч байгаа нь энэхүү аяллыг манайд хөгжүүлэхэд сайн нөлөө үзүүлж байна. Хэдий тийм боловч мэргэшсэн хөтчийн асуудал энэ аяллыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэхэд тулгамдсан бэрхшээл болсон хэвээр байна.

Манайд одоогоор шувуу ажиглах аяллын түгээмэл болсон цөөхөн маршрут байгаа бөгөөд үүнээс өөр бүтээгдэхүүнийг сүүлийн жилүүдэд нэмж санал болгоогүй байгаа. Тэдгээрийн нэг нь Улаанбаатар-Хустай-Хархорин-Өгий нуур-Бөөнцагаан-Гурван сайхан уул-Даланзадгад-Улаанбаатар гэсэн маршрут байна. Үүний гол

шалтгаануудын нэг нь тухайн бүс нутгийн шувуудын мэдээлэл хомс ялангуяа аялал зохион байгуулагддаг Тусгай хамгаалалттай газруудад судалгааны ажил хийгддэггүй, энэ чиглэлээр холбогдох яамнаас нь дорвитой арга хэмжээ авч чадахгүй байгаатай холбоотой. Түүнчлэн аялал зохион байгуулдаг компаниудын аяллын хөтөлбөр боловсруулдаг менежер болон хөтчүүдийн шувуу, байгаль орчны талаарх мэдлэг бага байгаатай мөн холбоотой юм. Иймд тур операторууд одоогийн цөөхөн бэлэн бүтээгдэхүүнийг жуулчдад санал болгосоор байна.

Гэтэл баруун бүсэд Увс, Хар ус, Хяргас нуурууд, зүүн бүсэд Ганга, Буйр, Хөх нуурууд, төвийн бүс буюу Хангай, Хөвсгөл, Хэнтийн нурууд гээд шувуудын аялал жуулчлал хөгжүүлэх боломж хангалттай байна. Харамсалтай нь эдгээр бүсүүд шувуудын зүйлийн бүрдлийн хувьд баялаг боловч гадаад, дотоодын жуулчдыг хүлээж авах тохилог бааз болон дэд бүтцийн хөгжил муу байгаагаас дээрх бүс нутгуудад шинэ аяллын бүтээгдэхүүн боловсруулахад бэрхшээл болдог.

Өмнөх жилүүдтэй харьцуулахад сүүлийн 10 жилд манай оронд шувуу ажиглах аяллыг хөгжүүлэх боломжууд харьцангуйгаар сайжирч байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн нислэг хийдэг компаниудын тоо нэмэгдсэн, зам дэд бүтэц сайжирсан, монгол орны шувуудын талаар таних бичиг, тэдгээрийн тархалтыг харуулсан ном, шувууны улаан данс, шувуудад чухал газар нутгууд зэрэг бүтээлүүд хэвлэгдсэн, мөн шувуу сонирхогч залуусын тоо өссөн зэрэг нь энэ төрлийн аяллыг цаашид хөгжүүлэхэд таатай нөхцлүүд болж байгаа юм.

Манай орны шувуудын дийлэнх зүйлүүд нь Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) шалгуураар мэдээлэл дутмаг гэсэн ангилалд ордог (Gombobaatar et al. 2011). Үүнийг үндэсний шувуу судлаачид болон шувуу ажиглагчид цөөн байгаатай холбоотой гэж тайлбарладаг. 2000 оноос хойш манайд ирсэн шувуу ажиглагчид өөрсдийн аяласан газрын нэрс, шувуудын жагсаалтыг гарган, тэмдэглэл хөтлөн интернэтэд байрлуулсан нь шувууны аяллыг зохион байгуулж буй тур операторуудад сайн зүйл болж байна.

Үндсэндээ манайд ирж буй мэргэжлийн шувуу сонирхдог жуулчид Монголд харахыг хүссэн Төв Ази тэр дундаа Монголын өндөрлөгийн

унаган зүйлүүд гэж хэлж болохуйц 40 орчим зүйл шувуудын нэрсийг жагсаан ирдэг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь манай орны хээр болон говийн бүсээр тархалттай шувууд байдаг. Жишээ нь хулан жороо *Podoces hendersoni*, монгол ногтруу *Syrhaptes paradoxus*, цөлийн зэржгэнэ *Sylvia nana*, цөлийн чогчого *Oenanthe deserti*, загийн боршувуу *Passer ammodendri*, Дорнын хиазат *Charadrius veredus*, мөн монгол болжмор *Melanocorypha mongolica*, монгол газрын боршувуу *Pyrgilauda davidiana* зэргийг дурьдаж болно. Дээр дурдсан түгээмэл маршрутаар эдгээр зүйлүүдээс гадна маш ховор таарах өндөр уулын өгөөлэй шулганаа *Saxicola insignis*, козловын хайруулдай *Prunella kozłowi*, алтайн хойлог *Tetraogallus altaicus* зэрэг шувуудыг харах боломжтой байдаг.

Шувуу ажиглах аяллын нөөц, боломж

Одоогоор Монгол оронд 19 багийн 61 овгийн 203 төрлийн 476 зүйл шувууд албан ёсоор бүртгэгдсэн байдаг (Болд ба бусад, 2007). Эдгээрээс оршин амьдрах хэлбэрийн хувьд 81 зүйл нь суурин амьдралтай бол 395 нь нүүдлийн шувууд юм. Нүүдлийн шувуудаас өндөглөн зусдаг 254, дайрч өнгөрдөг 49, Сибирээс ирж өвөлждөг 10, зөвхөн зундаа зусдаг 8, тохиолдлоор үзэгддэг 64, өндөглөдөг эсэх нь бүрэн батлагдаагүй 6 зүйл шувууд тус тус байна (Болд ба бусад, 2007). Олон улсын хэмжээнд ховордох аюулд өртсөн 17 зүйл, бүс нутгийн хэмжээнд 36 зүйл байгаа гэж үнэлэгдсэн (Gombobaatar and Monks, 2011).

Дэлхий дээр 10000 гаруй зүйлийн шувууд байдгаас Ази тивд 2900, Европт 842, Хойд Америкт 2000 орчим, Өмнөд Америкт 3200, Австрали тив түүний орчмын арлуудаар 1700 гаруй, Антарктид тивд 70 орчим зүйл шувуу бүртгэгдээд байгаа (<http://avibase.bsc-eoc.org/checklist.jsp?region=euc>). Монгол оронд Төв Азийн, Зүүн Ази-Австралийн, Африк-Еврази дамнасан хэмээх Дэлхийд тогтоогдсон нүүдлийн 3 үндсэн замаар дамжин шувууд нүүдэллэдэг. Эдгээрийн эхний хоёр замаар Монгол орны шувуудын дийлэнх нь дамждаг байна (Болд et al. 1998).

Эдгээр нүүдлийн 3 үндсэн замуудад баруун бүс нутагт Хар Ус, Айраг, Увс, Хяргас зэрэг их нууруудын хотгорын бүлэг, Төвийн бүсэд Бөөн цагаан, Таацын цагаан, Тэрхийн цагаан, Өгий, Сангийн далай, Эрхэл, Хөвсгөл зэрэг

нуурууд, Хан Хэнтийн нуруу, Хурх Хүйтний голын хөндий, Онон, Туул голын сав газрууд, Дундад Халхын хээрээр дамжин Галбын говь зэрэг багтана. Харин дорнод бүсэд Дарьганга, түүний орчмын нуурууд, Халх голын сав, Хэрлэн, Улз голын хөндий, Дагуурын бүс нутаг багтдаг байна. Эдгээр замуудыг дамнан шувууны аялал жуулчлал хөгжүүлэх нь зүйтэй. Учир нь эдгээр замууд нь нүүдлийн олон зүйл шувуудыг нэг дор харах нөөц байгаатай илэрхийлж байна.

Дэлхий дээр шувуудын зүйлийн тоогоор дээгүүр бүртгэлтэй Перу, Бразил, Конго, Энэтхэг зэрэг улс нь 1500-3000 хүргэлх зүйлийн шувуудтай тул энэ төрлийн аялал жуулчлал харьцангуй хурдацтай хөгжсөн (Krüger 2005, Puhakka et al. 2011). Харин Монгол орны хувьд дээрх улсуудтай адил олон зүйлийн шувуудгүй ч хангай, хээр, говь, цөл гэх ялгаатай амьдрах орчинд тохиолдох шувуудын өвөрмөц бүрдэлтэйгээс гадна, жуулчдын хувьд Монгол орны онгон зэлүүд байгаль, зэрлэг амьтан, ургамал зэрэг нь тэдний сонирхолыг ихээр татдаг байна.

Түүнчлэн Шувуудад чухал газар нутгуудыг тодорхойлсон судалгаа хийгдэж, Монгол орны хэмжээнд 70 газар бүртгэгдсэн (Нямбаяр ба Цэвээнмядаг 2009). Эдгээр газруудыг түшиглэн шувуудын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн тохиромжтой. Энэ бол шувуу ажиглах аялал жуулчлал хөгжүүлэх олон нөөц бололцоо байгаагийн нэг жишээ мөн. Тиймээс манай орон олон улсын аялал жуулчлалын зах зээлд шувуу ажиглах аялалаар томоохон зорилт тавин шувуудын талаарх судалгааг сайтар нягтлан үзэж, дээрх бүс нутгуудад тархах ховор болон нэн ховор шувуудыг тодорхойлж, амьдрах орчны онцлог бүрт харгалзуулан аяллын маршрут хийж, төрөлжүүлэн бүтээгдэхүүн болгон гаргавал энэ аяллыг тогтвортой хөгжүүлэх боломжтой юм. Харин хэрэглэгчдийн сонирхолыг татсан үр дүнтэй бүтээгдэхүүн боловсруулахын тулд аялал жуулчлалын компаниудаас гадна шувуу судлалын мэргэжлийн байгууллагуудын оролцоо чухал.

Мэргэжлийн хөтөч

Гадны олон оронд шувууны аяллын хөтчийг сургах тал дээр мэргэжлийн байгууллагууд зөвлөгөө өгч, арга зүй боловсруулан, энэ

чиглэлээр аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран ажилладаг. Гэвч ихэнх мэргэжилтнүүд хүүхэд багачуудыг багаас нь байгальд хайртай болгох, шувуудыг таньж мэдэх сонирхолтой болгох нь ирээдүйн мэргэжлийн хөтөч нарын нөөцийг бий болгох үндэс нь болдог гэж үздэг (Krüger 2005, Puhakka et al. 2011).

Хүүхэд залуучуудын шувууны талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд юуны түрүүнд шувуу ажиглах аялал, хөтөлбөрт хамруулах нь чухал. Тэд үүнээс өөрсдийн сонирхол, хүсэл тэмүүллийг олж авдаг бөгөөд энэ нь цаашлаад хобби болон хөгжих үндэс болдог байна. Учир нь хобби хүнийг хөгжүүлдэг. Тэд шувууны аялалд оролцон шувуудын гайхамшгийг мэдэрч, өөрсдийн харах дуртай шувууг олж мэддэг. Мэдээж хүссэн хүн бүр шувуу ажиглагч болж чадна. Гагцхүү түүндээ цаг гарган, сэтгэл бас зүтгэлтэй байх хэрэгтэй. Шувууны сонирхолтой аялалуудад оролцсоны дараа тэд шувуу ажиглах аялалд цаг гаргаж чаддаг болох ба ингэснээр тэд нэг л мэдэхэд шувуудын талаар сайн мэдлэгтэй болж хөгждөг. Тиймээс шувуу ажиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клуб, нийгэмлэгүүдийг дэмжиж ажиллах хэрэгтэй байна.

Манайд шувуу ажиглах аялалд тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн хөтөч гэж байхгүй. Одоогоор шувуу ажиглах аяллын хөтчөөр ихэвчлэн мэргэжлийн шувуу судлаачид ажиллаж байгаа. Харамсалтай нь эдгээр мэргэжлийн шувуу судлаачдын судалгааны үе нь гадны жуулчдын Монголд аялах улиралтай давхцдаг учир үүнд байнга оролцох боломжгүй байдаг. Шувуу судлаачид мэргэжлийн хөтчийг сайн хийж чаддаг ч хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг хангалуун байлгах үүднээс аяллын хөтчид шаардагдах бусад чадваруудыг давхар эзэмжих зайлшгүй шаардлагатай болдог.

2013 оны хавар Соёл, спорт аялал жуулчлалын яам бусад төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран тусгай сонирхолын аяллуудын хөтөч бэлтгэх сургалт зохион байгуулж, олон залуус хамрагдан үр дүнтэй сайн ажил болсон.

Олон улсын түвшинд шувуу ажиглах аяллын мэргэжлийн хөтөч нарт тавигдах үндсэн шаардлага нь шувуудыг таних чадвартай, дуугаар нь ялгадаг, мөн тэдгээрийг хаанаас хэзээ олж харуулахаа мэддэг байх явдал юм. Гэтэл энэ бүхнийг мэддэг, шувууны чадварлаг

хөтчийг бэлтгэхэд нэлээдгүй цаг хугацаа, хөрөнгө санхүү шаардлагатай болдог.

Шувууны аяллын хөтөч болж байгаа хүн заавал бүх шувуудыг таньдаг байх шаардлагагүй. Гагцхүү хэрэглэгчдийн харахыг хүссэн шувуудыг хаанаас хэзээ олж харж болохыг мэддэг байх нь чухал юм. Учир нь мэргэжлийн шувуу ажиглагчид өөрсдөө шувуудыг хараад таних чадвартай, харин тэдэнд тухайн шувуудыг хаанаас олж харах асуудал илүү чухал байдаг. Тиймээс шувуу ажиглах аяллын хөтөч нарт зайлшгүй мэдэх шаардлагатай зүйлсийг хэрхэн оновчтойгоор эзэмшүүлэх, шувуу ажиглах сонирхолыг нь нэмэгдүүлэх тал дээрх арга зүйг олон улсын туршлагаас судлах хэрэгтэй байна.

Санал, зөвлөмж

Ихэнх мэргэжилтнүүд хүүхэд багачуудыг багаас нь байгальд хайртай болгох, шувуудыг таньж мэдэх сонирхолтой болгох нь ирээдүйн мэргэжлийн хөтөч нарын нөөцийг бий болгох үндэс нь болдог гэж үздэг. Тиймээс шувуу ажиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клуб, нийгэмлэгүүдийг байгуулах, дэмжиж, ажиллах хэрэгтэй байна.

Тогтвор суурьшилтай мэргэжлийн хөтчийг бэлтгэхэд цаг хугацаа ихээхэн шаардлагатай. Хэдий тийм боловч шувуу судлалын чиглэлээр ажиллаж буй залуу судлаачидтай мэргэжлийн хөтчийн гэрээ хийх замаар ажиллах боломжтой.

Бүс бүрт амьдрах шувуудын өвөрмөц бүрдлийг илэрхийлсэн чанартай бүтээгдэхүүн боловсруулж олон улсад зохион байгуулагддаг Bird Fair зэрэг шувуу ажиглах аяллын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд оролцох, сурталчлах хэрэгтэй байна.

Аялал жуулчлалын компаниуд өнөөгийн байгаа нөөц боломж дээрээ тулгуурлан шувуу ажиглах аяллыг төрөлжүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд тухайн бүс нутагт байх шувуудын онцлогийг харгалзан аяллын шинэ бүтээгдэхүүнийг бий болгоно. Жишээ нь Зүүн бүсэд Хурх Хүйтний хөндий, Онон голын сав газар, Монгол Дагуурын хээрийн ус намгархаг газрыг хамруулан Цэн тогоруунд түшиглэн тэр орчмын бусад зүйлийн ховор шувуудыг харуулах боломжтой. Харин баруун бүсэд Их нууруудын хотгорт Хар-Ус, Хяргас, Увс зэрэг томоохон нуурууд, тэдгээрт байх ховор

шувууд (борцгор хотон *Pelecanus crispus*, усны нөмрөгбүргэд *Haliaeetus leucoriphus*)-ыг түшиглэн олон зүйл шувуудыг нэг дороос харах аяллын бүтээгдэхүүн бий болгох боломжтой. Энэ тал дээр холбогдох байгууллагууд хамтран чанартай бүтээгдэхүүн боловсруулж, яамны зүгээс олон улсад сурталчилах тал дээр санхүүжилтээр дэмжин, анхааран ажиллах шаардлагатай байна.

Манай орны аялал жуулчлалын дийлэнх нь Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн хийгдэж байна. Харамсалтай нь ихэнх Тусгай хамгаалалттай газруудын биологийн олон янз байдлын мэдээлэл дутмаг хэвээр байгаа. Гэтэл шувууны аяллыг төрөлжүүлэн хөгжүүлэхэд тухайн бүс нутгийн шувууны мэдээлэл хамгийн чухал үүрэгтэй байдаг. Иймд холбогдох яамнаас энэ тал дээр анхаарал хандуулж Тусгай хамгаалалттай газар нутгуудын судалгааны ажлуудыг дэмжиж ажиллах хэрэгтэй.

Мэргэжлийн шувууны хөтөч нарт зориулан сүүлийн үеийн дэвшилтэт мэдээллийн технологийг ашиглан гарын авлага бэлдэж, тэдний сурах сонирхол болон чадварыг хөгжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл Монгол орны шувуудыг таньж тодорхойлох фото лавлах болон тархацыг харуулсан газрын зураг мөн тэдгээрийн дуу зэрэг үндсэн 3 мэдээллийг багтаасан ухаалаг утасны аппликэшн бэлдэж өгөх нь үр дүнтэй байж болох юм. Энэ ажил дээр мэргэжлийн байгууллагын судлаачидтай хамтран ажиллавал шувууны мэргэжлийн хөтчийг бэлтгэхэд хамгийн энгийн, цаг хугацаа хэмнэсэн, ашиглахад хялбар, оновчтой аргуудын нэг болно. Хэдийгээр Монгол орны шувуудын талаарх судалгаа бага, мэдээлэл дутмаг ч энэ төрлийн электрон гарын авлагыг гаргах мэдээ материал хангалттай бүрдээд байна.

Ашигласан бүтээл

- Alderfer, J. and J. L. Dunn. 2007. National Geographic Birding Essentials. National Geographic.
- Christ, C., O. Hillel, S. Matus, and J. Sweeting. 2003. Tourism and biodiversity – mapping tourism's global footprint. Conservation International, Washington, DC.
- Dunne, P. 2003. Pete Dunne on bird watching : the how-to, where-to, and when-to of birding. Houghton Mifflin, Boston.
- Gombobaatar, S., E. M. Monks, R. Seidler, D. Sumiya,

- N. Tseveenmyadag, S. Bayarkhuu, J. E. M. Baillie, S. Boldbaatar, and C. Uuganbayar, editors. 2011. Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia, and Mongolian Ornithological Society.
- Krüger, O. 2005. The role of ecotourism in conservation: panacea or Pandora's box? *Biodiversity & Conservation* **14**:579-600.
- Puhakka, L., M. Salo, and I. E. Sääksjärvi. 2011. Bird Diversity, Birdwatching Tourism and Conservation in Peru: A Geographic Analysis. *PLoS One* **6**:e26786.
- Pullis La Rouche, G. 2006. Birding in the United States: a demographic and economic analysis. Pages 841-846 in G. C. Boere, C. A. Galbraith, and D. A. Stroud, editors. *Water birds around the world*. The Stationery Office, Edinburgh, UK.
- Болд, А., Д. Сумъяа, and Ш. Болдбаатар. 1998. Монгол орны ус намгийн шувууд, тэдгээрийг хамгаалах асуудал. Монгол улсын их сургуулийн Биологийн факультетийн эрдэм шинжилгээний бичиг **7**:11-25.
- Ганхуяг, П. and Г. Амархүү. 2012. Шувуу ажиглах хобби, түүний ач холбогдол ба Монгол дахь хөгжил. *Аялал амралт сэтгүүл* **2**:44-46.
- Нямбаяр, Б. and Н. Цэвээнмядаг. 2009. Монгол дахь шувуудад чухал газруудын лавлах: Байгаль хамгааллын түшиц нутгууд. Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, ШУА-ийн биологийн хүрээлэн, BirdLife International, Улаанбаатар.